



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/626

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Х/74 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 6 дугаар баг Жаргалантын ам, Буриадын хороо, Жаргалант зуслан чиглэлийн шороон хучилттай авто замын зорчих хэсэг нь 2024 оны зун орсон хүчтэй аадар бороо, үерийн улмаас эвдэрсэн тул зорчих хэсгийн авто замын засвар, арчлалтыг мэргэшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, иргэдийг аюулгүй зорчих орчныг бүрдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажилд 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Авто замын хяналтын Улсын байцаагч (С.Сүхбаатар), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д тус тус даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн авто замын сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр тухай бүр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010867